



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/75/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2023 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512127</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 9 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 11 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 13 |
| 4.2 Материаллаг байдал | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 14 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 15 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ С.СЭЛЭНГЭ ТАНАА

᠑᠙᠘3. ᠐᠗. 24 № ᠖᠗
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын эрүүл мэндийн төв эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулагдаагүй 22,168.2 мянган төгрөгийг харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоож, үр дүн, гүйцэтгэлээр нь санхүүжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>100,874,179.48</u> | <u>63,693,673.95</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 7,072,118.75 | 22,168,239.89 |
| 31140 | Касс арилжааны банк | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 7,072,118.75 | 22,168,239.89 |
| 3121 | Төгрөг | 7,072,118.75 | 22,168,239.89 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 627,258.52 | 22,168,239.89 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 6,444,860.23 | - |
| 33 | АВЛАГА | 73,507,200.00 | - |
| 335 | Бусад авлага | 73,507,200.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 73,507,200.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 20,294,860.73 | 41,525,434.06 |
| 351 | Түүхий эд материал | 14,427,060.73 | 36,020,834.06 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,776,724.50 | 28,210,214.50 |
| 35130 | Эм боох материал | 12,650,336.23 | 7,810,619.56 |
| 354 | Хангамжийн материал | 5,867,800.00 | 5,504,600.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 251,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,119,300.00 | 88,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 350,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,748,500.00 | 4,815,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>465,728,829.03</u> | <u>606,833,131.39</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 465,728,829.03 | 606,833,131.39 |
| 392 | Биет хөрөнгө | 451,742,029.03 | 591,045,359.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 212,745,075.00 | 212,745,075.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (18,743,285.52) | (25,536,283.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,125,234.00 | 160,125,234.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (19,770,195.48) | (22,743,838.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 306,019,337.09 | 350,784,932.09 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (95,211,330.98) | (138,405,903.27) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,875,900.00 | 87,004,965.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,152,767.73) | (33,244,433.96) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,142,250.00 | 3,142,250.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,469,187.35) | (3,007,637.31) |
| 39217 | Ном | 181,000.00 | 181,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 13,986,800.00 | 15,787,772.20 |
| 39301 | Програм хангамж | 1,020,000.00 | 3,015,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,020,000.00) | (1,214,027.80) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,986,800.00 | 13,986,800.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>566,603,008.51</u> | <u>670,526,805.34</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>566,603,008.51</u> | <u>670,526,805.34</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 566,603,008.51 | 670,526,805.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 333,437,596.80 | 333,437,596.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 333,437,596.80 | 333,437,596.80 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 200,472,417.23 | 304,396,214.06 |

| | | | |
|----------|--|------------------------------|------------------------------|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 200,472,417.23 | 200,472,417.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 103,923,796.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 32,692,994.48 | 32,692,994.48 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>566,603,008.51</u> | <u>670,526,805.34</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,105,393,649.00 | 959,476,667.50 |
| 110003 | Хөрөнгийн орлого | | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 223,327,200.00 | 183,157,957.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 149,820,000.00 | 183,157,957.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 149,820,000.00 | 183,157,957.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 149,820,000.00 | 183,157,957.50 |
| 122 | Тусламжийн орлого | 73,507,200.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 73,507,200.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 882,066,449.00 | 776,318,710.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 435,613,400.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 435,613,400.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 383,868,819.00 | 988,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 383,729,419.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 139,400.00 | 988,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,596,000.00 | 26,314,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,596,000.00 | 26,314,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 40,988,230.00 | 749,016,410.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 40,988,230.00 | 749,016,410.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 853,782,055.31 | 855,552,870.67 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 853,782,055.31 | 855,552,870.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 809,566,229.07 | 855,552,833.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 384,201,465.79 | 426,514,296.82 |
| 210101 | Үндсэн цалин | 303,222,157.62 | 291,732,212.31 |
| 210102 | Нэмэгдэл | 65,125,672.82 | 63,001,564.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,145,453.78 | 5,586,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,708,181.57 | 63,947,939.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 2,246,581.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,633,754.42 | 69,158,588.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,401,548.48 | 52,205,590.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,326,299.37 | 4,808,960.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,702,046.43 | 3,430,173.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,113,276.97 | 760,003.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,090,583.17 | 7,953,859.49 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,439,570.86 | 22,022,012.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,816,827.56 | 4,885,834.78 |
| 210302 | Түлш, халаалт | 13,622,743.30 | 15,536,177.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,600,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,197,810.00 | 65,048,449.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,955,990.00 | 9,291,018.54 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,401,720.00 | 34,425,982.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,451,000.00 | 1,774,550.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 16,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,389,100.00 | 3,125,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 16,415,799.06 |
| 2105 | Нормативт зардал | 185,821,759.02 | 181,095,784.07 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 147,468,099.02 | 143,003,464.07 |
| 210502 | Хоол, хүнс | 29,191,860.00 | 31,862,620.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,161,800.00 | 6,229,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,892,660.00 | 12,643,622.50 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,353,800.00 | 4,753,672.50 |
| 210602 | Тавилга | 14,183,960.00 | 3,225,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 354,900.00 | 4,664,950.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 736,000.00 | 608,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 736,000.00 | 608,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 32,647,466.05 | 8,558,021.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,647,466.05 | 8,305,021.90 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 253,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,995,742.93 | 69,904,057.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,204,491.20 | 2,118,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,791,251.73 | 67,785,357.64 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,215,826.24 | 37.62 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 44,215,753.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 44,215,753.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 73.24 | 37.62 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 73.24 | 37.62 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 251,611,593.69 | 103,923,796.83 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 251,611,593.69 | 103,923,796.83 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 882,066,449.00 | 856,898,028.75 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 882,066,449.00 | 856,898,028.75 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 435,613,400.00 | - |

| | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 435,613,400.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 383,868,819.00 | 988,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 383,729,419.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 139,400.00 | 988,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,596,000.00 | 26,314,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,596,000.00 | 26,314,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 40,988,230.00 | 829,595,728.75 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 40,988,230.00 | 829,595,728.75 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>838,941,530.25</u> | <u>753,755,483.86</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 838,941,530.25 | 753,755,483.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 794,725,706.31 | 753,755,446.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 383,611,404.59 | 426,514,296.82 |
| 210101 | Үндсэн цалин | 281,255,623.00 | 287,395,610.54 |
| 210102 | Нэмэгдэл | 82,369,962.30 | 67,338,166.12 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,025,453.78 | 5,586,000.00 |
| 210104 | Урамшуулал | 12,960,365.51 | 63,947,939.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 2,246,581.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,561,695.77 | 69,158,588.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,988,495.77 | 52,205,590.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,147,200.00 | 4,808,960.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,481,200.00 | 3,430,173.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,442,400.00 | 760,003.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,502,400.00 | 7,953,859.49 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,373,026.76 | 20,134,634.78 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,816,827.56 | 4,885,834.78 |
| 210302 | Түлш, халаалт | 11,556,199.20 | 13,648,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,600,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 54,978,040.00 | 47,938,182.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,083,280.00 | 7,548,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,281,560.00 | 35,568,732.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,335,000.00 | 1,751,250.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,278,200.00 | 3,070,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 209,591,916.94 | 155,555,645.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 161,671,176.94 | 113,073,595.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,477,680.00 | 31,501,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,443,060.00 | 10,980,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,119,160.00 | 18,853,827.60 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,129,700.00 | 4,674,800.00 |
| 210602 | Тавилга | 14,766,560.00 | 1,997,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 590,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,222,900.00 | 11,592,027.60 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 736,000.00 | 1,213,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 736,000.00 | 1,213,000.00 |

| | | | |
|--------|--|------------------------|------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,209,071.05 | 8,876,171.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,209,071.05 | 8,623,171.90 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 253,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,545,391.20 | 5,511,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,545,391.20 | 5,511,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,215,823.94 | 37.62 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 44,215,750.70 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 44,215,750.70 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 73.24 | 37.62 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 73.24 | 37.62 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>43,124,918.75</u> | <u>103,142,544.89</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 32,452,800.00 | 80,974,305.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 32,452,800.00 | 80,974,305.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 32,452,800.00 | 80,974,305.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,452,800.00 | 80,974,305.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(32,452,800.00)</u> | <u>(80,974,305.00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 10,672,118.75 | 22,168,239.89 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 7,072,118.75 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,072,118.75 | 22,168,239.89 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|------------------------|-------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | (57,234,937.06) | | 308,895,654.22 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | (57,234,937.06) | - | 308,895,654.22 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 257,707,354.29 | | 257,707,354.29 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | 200,472,417.23 | - | 566,603,008.51 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | 200,472,417.23 | - | 566,603,008.51 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | 200,472,417.23 | - | 566,603,008.51 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 103,923,796.83 | | 103,923,796.83 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 333,437,596.80 | 32,692,994.48 | 304,396,214.06 | - | 670,526,805.34 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-----|----------|------------|-----------------------------|
|-----|----------|------------|-----------------------------|

| | | | |
|-------------|--|------------------------|----------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,003,471,900.0 | 834,729,751.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,003,471,900.0 | 834,729,751.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,003,471,900.0 | 834,729,751.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 537,227,600.0 | 426,514,296.8 |
| 210101 | Үндсэн цалин | 446,894,000.0 | 287,395,610.5 |
| 210102 | Нэмэгдэл | 75,703,600.0 | 67,338,166.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,875,000.0 | 5,586,000.0 |
| 210104 | Урамшуулал | 11,755,000.0 | 63,947,939.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 2,246,581.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,483,800.0 | 69,158,588.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,209,000.0 | 52,205,590.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,318,700.0 | 4,808,960.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,254,900.0 | 3,430,174.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,063,800.0 | 760,003.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,637,400.0 | 7,953,859.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,534,300.0 | 20,134,634.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,285,500.0 | 4,885,834.8 |
| 210302 | Түлш, халаалт | 13,648,800.0 | 13,648,800.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,600,000.0 | 1,600,000.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,673,500.0 | 49,880,082.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,937,500.0 | 8,847,900.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,316,000.0 | 35,568,732.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,207,900.0 | 2,393,250.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,212,100.0 | 3,070,200.0 |
| 2105 | Нормативт зардал | 192,982,600.0 | 162,716,485.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 135,305,100.0 | 120,234,435.0 |
| 210502 | Хоол, хүнс | 42,864,700.0 | 31,501,250.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,812,800.0 | 10,980,800.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 88,718,500.0 | 76,980,892.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,718,500.0 | 15,430,800.0 |
| 210602 | Тавилга | 51,500,000.0 | 43,868,065.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.0 | 590,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 25,500,000.0 | 17,092,027.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,782,900.0 | 1,213,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,782,900.0 | 1,213,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,732,600.0 | 13,371,171.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,952,600.0 | 8,623,171.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,780,000.0 | 4,748,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,336,100.0 | 14,760,600.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,336,100.0 | 14,760,600.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,003,471,900.0 | 849,825,910.0 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 26,314,300.0 | 26,314,300.0 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 860,765,400.0 | 822,523,610.0 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 860,765,400.0 | 822,523,610.0 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 116,392,200.0 | 988,000.0 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 116,392,200.0 | 988,000.0 |

| | | | |
|---|---|---|--------------|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 7,072,118.8 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 22,168,239.9 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв “Үйлчлэх хүрээний хүн амд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэвшилтэд технологид тулгуурлан тэгш хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулалгүй үзүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,923.8 мянган төгрөгөөр буюу 18.34 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 7,072.1 | 22,168.2 | 15,096.1 |
| Авлага | 73,507.2 | - | (73,507.2) |
| Бараа материал | 20,294.9 | 41,525.4 | 21,230.5 |
| Үндсэн хөрөнгө | 465,728.8 | 606,833.1 | 141,104.3 |
| Нийт хөрөнгө | 566,603.0 | 670,526.8 | 103,923.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 566,603.0 | 670,526.8 | 103,923.8 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 566,603.0 | 670,526.8 | 103,923.8 |

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,096.12 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Авлагын данс 73,507.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 606,833.1 мянган төгрөг болж 141,104.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 80,974.3 мянга, үнэ төлбөргүй 3,915.3 мянга, шилжүүлж авсан 124,000.0 мянга нийт 208,889.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 103,923.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулдаг.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 860,765.4 мянга, орон нутгийн санхүүжилт 26,314.3 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 116,392.2 мянга нийт 1,003,471.9 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 834,729.7 мянган төгрөг буюу 83 хувийг урсгал зардалд зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|---|------------|-----------|-------|---------|
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 21,534.3 | 21,534.3 | - | 100 |
| 2 | 83201- Ангилалдаагүй бусад зориулалт | 4,780.0 | 4,780.0 | - | 100 |

| | | | | | |
|--|---|-------------|-----------|-----------|----|
| | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 390,834.6 | 298,148.0 | 92,686.6 | 76 |
| | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж | 469,930.8 | 429,690.9 | 40,239.9 | 91 |
| | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 116,392.2 | 80,576.5 | 35,815.7 | 69 |
| | НИЙТ | 1,003,471.9 | 834,729.7 | 168,742.2 | 83 |

Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 168,742.2 мянган төгрөг хэмнэгдсэн харагдаж байгаа боловч ЭМДС-аас орлого гүйцэтгэлээр дутуу санхүүжсэн, мөн боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 853,782.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,075.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд бензин шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор 2,761.6 мянган төгрөгөөр өссөн байна. Хангамж, бараа материалын зардлууд 7,039.8 мянган төгрөгөөр буурсан бөгөөд үүнд 2021 онд ковидын цар тахалтай холбоотойгоор бензин шатахуун, ариутгал, халдваргүйжүүлэлттэй холбоотой зардлууд нөлөөлж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд 146 мэдээлэл оруулснаас 33 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн ба 2022 оны 4-р улирал, хагас бүтэн жилийн мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | /мянган төгрөгөөр/ Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------|-------------------------------|----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 34,456.8 | 2 | 34,456.8 | 100 |
| Төлбөрийн акт | 1 | 6,078.0 | 1 | 6,078.0 | 100 |
| Зөвлөмж | 4 | 40,073.8 | 4 | 40,073.8 | 100 |
| Нийт дүн | 7 | - | 7 | - | 100 |

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,287.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,273.1 мянган төгрөгийг зөрчил³-д төлбөрийн акт тогтоож, 15,014.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулж байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

- Тус байгууллагын ажилчдад үр дүнгийн урамшууллын тогтоосон дээд хэмжээнээс 6,341.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.
- Ажилчдын ээлжийн амралтын нөхөн олговрын 1 өдөрт ногдох дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос 931.6 мянган төгрөгийг дутуу бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/*, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь */төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/*, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.2 дахь, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын хавсралтын 2.1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

- Санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй, өмнөх оны хатгалтын хөлс болон ковидын үед ажилласны урамшуулал 9,747.4 төгрөг олгосон байна.
- Хоолны зардлаас хүүхдийн бэлэг, ахмадын баярын үйл ажиллагааны болон бусад зардалд 5,267.1 мянган төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь */ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/,* 14 дүгээр зүйлийн 14.4 дэх */ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/*, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 */батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/,* 41 дүгээр зүйлийн 2.2 дахь */батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/* заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд тайлант онд 146 мэдээлэл оруулснаас 33 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн ба 2022 оны 4-р улирал, хагас бүтэн жилийн мэдээллийг байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах;

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|---------------------|---|----------|
| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ээлжийн амралтын нөхөн олговор дутуу бодож олгосон | 1 | 931.6 | 1 | 931.6 | - | - | - | - | - | - | - | - |
| Үр дүнгийн урамшууллыг илүү бодож олгосон | 1 | 6,341.5 | 1 | 6,341.5 | | | | | | | | |
| Өмнөх оны өглөгийг санхүүгийн тайланд илэрхийлээгүй | 1 | 9,747.4 | | | 1 | 9,747.4 | | | | | | |
| Төсвийг зориулалт бус зарцуулсан | 1 | 5,267.1 | | | 1 | 5,267.1 | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 5 | 22,287.6 | 2 | 7,273.1 | 2 | 15,014.5 | 1 | - | - | - | - | - |